

Сэдэв 3. Санхүү, эдийн засгийн суурь ойлголтууд

П.Жаргалтуяа /Доктор(Ph.D.), профессор/



Агуулга:



1. Санхүү, эдийн засгийн суурь ойлголтууд
2. Санхүүгийн удирдлагын тухай ойлголт
3. Мөнгөний цаг хугацааны үнэ, цэнэ
4. Санхүүжилтийн эх үүсвэр, өртгийн тооцоолол

1. Эдийн засгийн суурь ойлголтууд


- **Эрэлт, нийлүүлэлт** : Худалдан авах чадвараар баталгаажсан хэрэгцээг эрэлт гэнэ. Нийлүүлэлт нь хэрэглэгчийн худалдан авах түвшинд зах зээлд нийлүүлэх боломжтой бүтээгдэхүүний тоо хэмжээ.
- **Валютын ханш**. Аль нэг улсын валютыг өөр нэг улсын валютаар илэрхийлсэн үнэ. Валютын ханш буюу гадаад валютын үнэ уг валютын эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдоно. Валютын ханш нь:
ЭРЭЛТ > НИЙЛҮҮЛЭЛТ → **ҮНЭ ӨСНӨ**; ЭРЭЛТ < НИЙЛҮҮЛЭЛТ → **ҮНЭ БУУРНА**
- **Инфляци** . Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт.
- **Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)** нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна

1. Эрэлт, нийлүүлэлтийн муруй

Эрэлт, нийлүүлэлтийн муруй




1. Монгол улсын инфляцийн түвшин /жилийн дундажаар/



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан

Хэмжих нэгж: хувь


1. Монгол улсын инфляцийн түвшин /хэрэглээний үнийн индексээр/



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан

Хэмжих нэгж: хувь

1. Валютын ханшны өөрчлөлт/сарын эцсээр/




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан

Хэмжих нэгж: төг

1. Санхүү, эдийн засгийн суурь ойлголтууд

- ***Хувьцаа.*** Компанид хөрөнгө оруулсан, өмч эзэмшигч болохыг, ногдол ашиг авах эрхийг батагаажуулсан үнэт цаас.
- ***Бонд.*** Засгийн газар болон хувийн компаниас төсөл, хөтөлбөр, хөрөнгө санхүүжилт босгох зорилгоор гаргасан, тодорхой хугацааны дараа үндсэн болон хүүгийн төлбөрөө буцаан төлөх нөхцөлтэй өрийн бичиг буюу үнэт цаас юм.
- ***Өгөөж, эрсдэл.*** Бусад хүчин зүйлс тогтмол байхад өгөөж өсөхийн хэрээр хөрөнгийн үнэ цэнэ өсөж, эрсдэл өсөхийн хэрээр хөрөнгийн үнэ цэнэ буурах зүй тогтолтой. Эрсдэл, өгөөжийг нэг хөрөнгийн хувьд тодорхойлохоос гадна багцын хувьд болон тодорхой бизнес, төслийн түвшинд тодорхойлж болно.
- ***Банкны хадгаламжийн болон зээлийн хүү.***
- ***Мөнгөний цаг хугацааны цэнэ.*** Мөнгө цаг хугацааны үнэ цэнэтэй.


ЗЭЭЛИЙН ХҮҮ/хувиар/




Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан

Хэмжих нэгж: хувь

ЖДҮ эрхлэгчдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл /ЭЗ-ийн салбараар/



Арилжааны банкны зээлийн хүүний түвшин



Эх үүсвэр: Монгол банкны тайлан мэдээ /2021/

2. Санхүүгийн удирдлагын тухай ойлголт

- **Санхүүгийн зах зээл** нь сул чөлөөтэй байгаа мөнгөн хөрөнгийг санхүүгийн зуучлагч байгууллагаар дамжуулан эргэлтэнд оруулж, хуримтлалыг хөрөнгө оруулалт болгох зорилготой.
- **Санхүүгийн менежмент** нь хурдтай хувьсан өөрчлөгдөж буй бизнесийн орчинд санхүүгийн нөөцийг бий болгох, үр ашигтай зарцуулах, хөрөнгө оруулалт болгох, оновчтой санхүүжилтийн шийдвэр гаргах процесс юм. Орлого, зарлагыг зөв төлөвлөж, санхүүгийн тогтвортой байдлыг хангана.

2. Санхүүгийн менементийн 3 түлхүүр элемент



3. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ гэдэг нь өнөөдрийн 1 төгрөг ирээдүйн 1 төгрөгөөс илүү үнэтэй гэдгийг илэрхийлдэг. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ:

- Хөрөнгө оруулалтын үр ашиг тооцоход
- Санхүүжилт, зээл авах шийдвэр гаргахад
- Хөрөнгө худалдан авах, хөрөнгийн үнэлгээ хийх
- Бусад

3. Ирээдүйн үнэ, цэнэ

Future value = FV

$$FV_n = PV \times (1 + r)^n$$

$$FV = PV \times FVIF_{r,n}$$

PV - Өнөөгийн үнэ цэнэ /Present value/

FV - Ирээдүйн үнэ цэнэ

r - хүүгийн түвшин (эрсдлийг тооцсон)

n - үеийн тоо

3. Ирээдүйн үнэ цэнэ

Дасгал ажил. Жилийн 12%-н хүүтэй 10,000,000 төгрөг хадгалуулбал 5 жилийн дараа хэдэн төгрөгтэй болох вэ?

1. Банк жилд нэг удаа хүү тооцдог. /1762234,68/
2. Банк хагас жилд нэг удаа хүү тооцдог
3. Банк сар бүр хүү тооцдог бол 10000000 төгрөгний 5 жилийн дараах үнэ цэнэ тооцно уу.

3. Үе тутмын мөнгөн урсгалын ирээдүйн үнэ цэнэ /тогтмол мөнгө/

- Хугацааны эхэнд дэхь мөнгөн урсгалын ирээдүйн үнэ цэнэ:


$$FVAN_{n=A} = A \times \left[\frac{((1+r)^{n+1} - 1)}{r} - 1 \right]$$

- Хугацааны эцэст дэхь мөнгөн урсгалын ирээдүйн үнэ:

$$FVAN_n = A \times \left[\frac{(1+r)^n - 1}{r} \right]$$

3. Ирээдүйн үнэ цэнэ

- Дасгал ажил: “Гутал” ХК компани банкнаас 50 сая төгрөгийн зээлийг жилийн 22% хүүтэй 3 жилийн хугацаатай авсан. Зээлийн хэт их дарамтанд орохгүйн тулд “Гутал” ХК зээлийг сар бүр тогтмол хэмжээгээр төлж дуусгахаар харилцагч банктайгаа гэрээ хийсэн. Сар бүр төлөх төлбөрийн хэмжээ ямар байх вэ.



Банкны зээлийн хүүгийн тооцоолол

Зээлийн тооцоолуур	Хадгаламжийн тооцоолуур	Гадаад шилжүүлэг тооцоолуур
<p>Таны хүсч буй зээлийн хэмжээ</p> <p><input type="range" value="100,000,000"/></p> <p>100,000,000 ₮</p>		<p>Жилийн хүү</p> <p>24 %</p>
<p>Зээл төлж дуусах хугацаа</p> <p><input type="range" value="60"/></p> <p>60 Сар</p>		<p>Сарын эргэн төлөлт</p> <p>2,876,797 ₮</p>
<p>Зээлийн жилийн хүү</p> <p><input type="range" value="24"/></p> <p>24 %</p>		<p>Төлбөл зохих нийт хэмжээ</p> <p>172,607,795 ₮</p>

Арилжааны банкны санхүүгийн үйлчилгээ

төгрөгөөр

Банк	Хадгаламжийн хүү /жил/	Бизнесийн зээлийн хүү/жил/	Зээлийн хугацаа	Санхүүгийн үйлчилгээний онцлог
ХХБ	12.8%	21.6%-26.4%	36 - 60 сар	Бизнес, хөрөнгө оруулалтын зээл
Голомт	11.7%	19.2%-22.8%	6-60 сар	Бизнесийн зээл
Хаан банк	12.8%	18%-20.4%	12-30 сар	Иргэдийн зээл

3. Өнөөгийн үнэ цэнэ

Present Value = PV

$PV = C_1 \times \text{discount factor}$

$PV = FV \times \frac{1}{(1+r)^n}$

PV - Өнөөгийн үнэ цэнэ /Present value/

FV - Ирээдүйн үнэ цэнэ

r - хүүгийн түвшин (эрсдлийг тооцсон)

n - үеийн тоо

3. ӨНӨӨГИЙН ҮНЭ ЦЭНЭ /Дасгал ажил/

- **Дасгал ажил.** Доржийн дараа жилийн оюутны сургалтын төлбөр 2,000,000 төгрөг болно. Доржийн найз түүнээс мөнгө зээлээд жилийн дараа Доржийн сургалтын төлбөрийг төлөхөөр тохирсон. Энэ үед хадгаламжийн хүү 12 хувь байсан бол Дорж найздаа хэдэн төгрөг зээлүүлэх вэ. /1785714,28/

$$PV=2000,000 \times (1/(1+0.12)^1) = 2000,000 \times 1/1.12 = 1785714,28$$

- **Дасгал ажил.** Таны хүүгийн 7 насны төрсөн өдөр болж байна. Таны нагац ах хүүгийн 18 насны төрсөн өдрөөр 150,000,000.0 төгрөг бэлэглэхээр болжээ. Хорогдуулалтын хүү 9% гэж тооцвол энэ мөнгөний өнөөгийн үнэ цэнэ хэд вэ? /58 129 927.6/

$$PV=150\,000,000 \times (1/(1+0.09)^{11}) = 58\,129\,927.6$$

3.Үе тутмын мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ

- Хугацааны эхэнд дэхь мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ

$$PVAn = A \times \left[\frac{\left[1 - \frac{1}{(1+r)^{n-1}} \right]}{r} + 1 \right]$$

- Хугацааны эцэст дэхь мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ

$$PVAn = A \times \left[\frac{\left[1 - \frac{1}{(1+r)^n} \right]}{r} \right]$$

Баярлалаа. 😊